



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/96

Улаанбаатар хот


### Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын “Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, дадлага сургууль, хамгаалалтын үед алба хаагчдад хувцас, хамгаалах хэрэгслийг энэхүү журмын дагуу өмсүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулан 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс мөрдүүлж ажиллахыг төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, захирагч наарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /бригадын генерал Т.Ариунбаян/-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2020 оны дугаар сарын 15-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

**ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ЗОРИУЛСАН ХАМГААЛАХ ТУСГАЙ ХУВЦАС, ХҮН НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ  
ХЭРЭГСЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, дадлага сургуульд оролцох үед алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогч, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтан, дайчлагдсан иргэд дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Журамд ашигласан нэр томьёог Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага CS 11-0439:2020, Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага CS 11-0440:2020 болон Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага CS 11-0441:2020 стандартуудад заасан нэр томьёоны тодорхойлолтоор ойлгоно.

Гурав. Хамгаалах тусгай хувцас, хэрэгсэл

3.1. Хамгаалах тусгай хувцас нь дараах хоёр төрөлтэй байна.

- Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцасны иж бүрдэл.

- Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцасны иж бүрдэл.

Дөрөв. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийн иж бүрдэл, хэрэглэх шаардлага.

4.1. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийн иж бүрдэл.

**Үндсэн хувцас:**

- Хүрэм;
- Дулаалгатай салдаг хүрэм;
- Өмд.

**Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл:**

- Дуулга;
- Дуулганы дотор малгай /подкаск/;

- Гар хамгаалах хэрэгсэл /бээлий/;
- Хөл хамгаалах хэрэгсэл /резинэн гутал/;
- Хамгаалалтын оймс;
- Аврах бүс;
- Аврах сүх;
- Карбин;
- Гэрэлтүүлэх хэрэгсэл.

#### **Дулаан эсэргүүцэх хувцас:**

- Комбинезон;
- Хүрэм;
- Өмд;
- Бээлий;
- Гутал.

4.2. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг хэрэглэх шаардлага.

4.2.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогч, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтнууд объектын гал түймэр унтраах, дадлага сургалт, урьдчилан сэргийлэх хамгаалалтад үүрэг гүйцэтгэх үед хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг хэрэглэж ашиглана.

4.2.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагч Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага CS 11-0439:2020, Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага CS 11-0441:2020 стандарттаар тогтоосон эдэлгээний хугацааны дагуу тусгай хувцас, хэрэгслээр үнэгүй, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтнууд ажил олгогчоос<sup>1</sup> хангагдана.

4.2.3. Үндсэн хувцас, тусгаарлах хувцас, дулаан эсэргүүцэх хувцсыг дараах тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

- Объектын гал түймэр унтраах,
- Дадлага сургууль хийх,
- Гал түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалалтад үүрэг гүйцэтгэх.

4.2.4. Хамгаалах тусгай хувцсыг дараах тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

- Дүрмийн бус хэрэглэх;
- Урагдаж цоорсон, сэмэрсэн;
- Хүйтний улиралд олон цагаар ажилласан хувцсыг дахин ашиглах;
- Аж ахуйн ажилд.

4.2.5. Объектын гал түймэр унтраах ажиллагаа, дадлага сургууль, хамгаалалтын үед алба хаагч, ажилтан нь гал түймэр унтраах удирдагч, ахалж буй албан тушаалтны шийдвэргүй хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг тайлахыг хатуу хориглоно.

4.2.6. Зайлшгүй тохиолдолд гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр хамгаалах тусгай хувцсыг хольж хэрэглэх, хэсэгчлэн болон бүрэн тайлж аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд оролцно.

<sup>1</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.“ажил олгогч” гэж хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг;

4.2.7. Зайлшгүй тохиолдолд /алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор/ хүн нэг бүрийн хэрэгслийг гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр нэмж тоноглож болно.

4.2.8. Объектын гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгслийг алба хаагчид биедээ зөв тохируулж зориулалтын дагуу хэрэглэнэ.

4.2.9. Объектын гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

- Гал түймэр унтраах дүрэмд заасны дагуу туршилтад хамруулаагүй;
- Эвдрэл, гэмтэлтэй, эдэлгээний хугацаа дууссан;
- Иж бүрдэл дутуу хамгаалах хэрэгсэл ашиглах;
- Аж ахуйн ажилд;
- Бусдад шилжүүлэх.

Тав. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийн иж бүрдэл, хэрэглэх шаардлага.

5.1. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийн иж бүрдэл. (хүйтний, дулааны)

#### **Хүйтний улирлын хамгаалах хувцас:**

- Дулаалгатай хүрэм (хүйтний улирлын);
- Дулаалгатай өмд (хүйтний улирлын);
- Дотуур хувцас;
- Хамгаалах нөмрөг;
- Тусгай тоноглолтой хантааз;
- Нүүр, ам, хүзүүний халхавч.

#### **Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл:**

- Дуулга;
- Нүд хамгаалах хэрэгсэл /нүдний шил/;
- Гар хамгаалах хэрэгсэл /бээлий/;
- Хөл хамгаалах хэрэгсэл /гутал/;
- Хосолсон ажиллагаатай хутга;
- Гэрэлтүүлэх хэрэгсэл.
- 

#### **Дулааны улирлын хамгаалах хувцас:**

- Цамц;
- Өмд;
- Хамгаалах нөмрөг;
- Тусгай тоноглолтой хантааз.

#### **Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл:**

- Дуулга;
- Нүүр, ам, хүзүүний халхавч;
- Нүд хамгаалах хэрэгсэл /нүдний шил/;
- Гар хамгаалах хэрэгсэл /бээлий/;
- Хөл хамгаалах хэрэгсэл /гутал/;
- Хосолсон ажиллагаатай хутга;
- Гэрэлтүүлэх хэрэгсэл.

5.2 Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг хэрэглэх шаардлага.

5.2.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогч, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтнууд ой, хээрийн гал түймэр унтраах, дадлага сургалт, урьдчилан сэргийлэх хамгаалалтад үүрэг гүйцэтгэх үед хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг хэрэглэж ашиглана.

5.2.2. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага CS 11-0440:2020, Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага CS 11-0441:2020 стандартаар тогтоосон эдэлгээний хугацааны дагуу тусгай хувцас, хэрэгслээр үнэгүй, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтнууд ажил олгогчоос<sup>2</sup> хангагдана.

5.2.3. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаа, дадлага сургууль, хамгаалалтын үед алба хаагч, ажилтан нь гал түймэр унтраах удирдагч, ахалж буй албан тушаалтны шийдвэргүй хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хэрэгслийг тайлахыг хатуу хориглоно.

5.2.4. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогч, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтан нь ой, хээрийн түймэр унтраах үйл ажиллагаанд оролцохдоо хамгаалах нэмрөгийг заавал биедээ авч явна.

5.2.5. Ой, хээрийн гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгслийг алба хаагчид биедээ зөв тохируулж зориулалтын дагуу хэрэглэнэ.

5.2.6. Хамгаалах нэмрөгийг дараах байдлаар ашиглахыг хориглоно.

- Стандартын бус хамгаалах нэмрөгийг ашиглах;
- Хамгаалах нэмрөгийг зориулалтын бусаар ашиглах.

### Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч, гал түймэр унтраах удирдагч нар хяналт тавина.

6.2. Журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

### Долоо. Бусад

7.1. Хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн чанар, эдэлгээний хугацаатай холбоотой санал, гомдлыг бичгээр буюу амаар шууд удирдах дарга, захирагч наарт уламжлан шийдвэрлүүлнэ.

7.2. Хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр алба хаагчийг гал түймэр унтраах аврах ажиллагаанд оролцуулахгүй байж болно.

--о0о--

<sup>2</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.“ажил олгогч” гэж хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг;

Хавсралт : Гэрэл зураг

1. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан тусгай хувцасны иж бүрдэл

а) Үндсэн хувцас



б) Дулаан эсэргүүцэх хувцас



2.Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан тусгай хувцасны иж бүрдэл

